



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41

И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2022.12.06 № 2/5409  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Үнийн санал авах тухай**

Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын мэдээний сан бүрдүүлэх ажлыг захиалагчийн зүгээс гаргасан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Оролцогч хуулийн этгээд дараах ажлын туршлагыг хангасан байна. Үүнд:

- Өгөгдлийн шинжилгээнд суурилсан судалгаа, үнэлгээ хийж байсан туршлагатай байх;
- Төрийн ба олон улсын байгууллагуудад хөгжлийн бодлого, стратегийн удирдлага, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх

Үнийн саналыг тухайн байгууллагын албан тоотоор хүлээж авах ба хүлээн авах эцсийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 00 минут бөгөөд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII дугаар байр 311 тоотод ирүүлнэ. Утас: 263820.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

*Ц. Эрдэмбилэг*

Ц.ЭРДЭМБИЛЭГ

145223646

## АЖЛЫН ДААЛГАВАР

<b>Зөвлөх үйлчилгээний нэр:</b>	Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын мэдээний сан бүрдүүлэх.
<b>Байршил:</b>	Монгол, Улаанбаатар
<b>Гэрээний төрөл:</b>	Дотоодын зөвлөх байгууллага
<b>Ашиглах хэл:</b>	Монгол
<b>Гэрээний үргэлжлэх хугацаа:</b>	80 ажлын өдөр

**Үндэслэл:** Тухайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт нь салбарын хөгжилд гол нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн нэг байдаг. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ тогтмол өссөөр ирсэн. Гэвч өнгөрсөн хугацаанд салбарт оруулсан хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээний сан байхгүйгээс хэрэгцээгээ зөв тодорхойлох, оновчтой төлөвлөхөд бэрхшээл тулгарсаар байна.

**Зорилго:** ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газар, Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтнүүдэд зориулан эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэрэгцээг судлах, оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг хянах боломж бүхий мэдээний нэгдсэн санг бүрдүүлж, мэдээний санг шинэ өгөгдлөөр баяжуулах боломжтой электрон хэрэгсэл бүтээх.

**Гүйцэтгэх ажлын хүрээ:** Захиалагчаас нийлүүлэх өгөгдөл, мэдээ, мэдээллийн хүрээнд Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээний сан бүрдүүлэхээр дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Үүнд.

- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах процесс, үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн баримт бичгүүд, тогтмол гаргадаг мэдээ, тайлангуудыг судалж төсөл, арга хэмжээний төрөл бүрээр (Барилга, Их засвар, Тоног төхөөрөмж) болон нэгдсэн мэдээний сангийн бүтцийг зураглаж, захиалагч талтай зөвшилцөж, тохиролцох.
- Захиалагч талтай тохиролцсон бүтцийн дагуу, төсөл, арга хэмжээний төрөл бүрээр Захиалагчаас хангасан өгөгдөл, мэдээллийн хүрээнд мэдээний санг үүсгэх
- Мэдээний санг шинэ өгөгдлөөр баяжуулах боломжтой болосвруулах.

### **Хүлээгдэж буй үр дүн буюу бүтээгдэхүүн:**

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Барилгын мэдээний сан
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Их засварын мэдээний сан
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Тоног төхөөрөмжийн мэдээний сан
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан төсөл, арга хэмжээний нэгдсэн мэдээний сан
- Төсөл, арга хэмжээний төрөл тус бүр болон нэгдсэн мэдээний санг шинэ өгөгдлөөр баяжуулах.

**Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллагын зөвлөхүүдэд тавигдах шаардлага:** Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан 2 зөвлөхийг ажиллуулах үүрэгтэй. Үүнд:

- Эдийн засаг, санхүү, бизнесийн удирдлагын мэргэжилтэй
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан (Эрүүл мэндийн салбарын санхүү эдийн засгийн чиглэлээр ажилласан туршлагатай бол давуу тал болно).
- Өгөгдлийн мэдээний сан үүсгэж, судалгаа, дүн шинжилгээ хийж байсан туршлагатай (Эрүүл мэндийн салбарын өгөгдлийн сантай ажиллаж байсан бол давуу тал болно)
- Microsoft excel программыг ахисан түвшинд эзэмшсэн, Power BI болон R, SPSS, STATA гэх судалгааны программ хангамжуудыг зохих түвшинд ашиглах чадвартай.

**Тайлагналт:** Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйл ажиллагаагаа ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтэст тайлагнана.